

МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

2023 оны 02 сарын 16 өдөр

№ 01

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

“Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК (цаашид “Сан” гэх)-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурал цахим санал хураалт авах хэлбэрээр хуралдав.

Хурлын дарга: Өлзийбаярын ГАНЗОРИГ

Хурлын нарийн бичгийн дарга: Балдан ЭНХТҮВШИН

Хуралд оролцсон төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоо: 4

Хурлын ирц: 80%

Хэлэлцэгдсэн асуудал зөвшөөрсөн: 80%

НЭГ. ТАНИЛЦАХ АСУУДАЛ

Сангийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар танилцуулах материал:

Танилцуулах материал	Танилцуулсан
Сангийн 01 дүгээр сарын үйл ажиллагааны тайлан	Б.Цолмон
Сангийн 2022 оны Санхүүгийн тайлан, Ногдол ашиг хувиарлах эсэх	Б.Цолмон

Танилцуулага:

Танилцуулсан, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Энхтүвшин

Сангийн үйл ажиллагааны тайлан

Компанийн тухай хууль, Сангийн холбогдох журам, дүрэмд заасны дагуу 2023 оны 02 сарын байдлаар Сангийн 2023 оны 1 сарын үйл ажиллагааны тайлан, Сангийн 2022 оны Санхүүгийн тайлан, Ногдол ашиг хуваарилах эсэх асуудлыг танилцуулахаар хүргүүлж байгаа тул та бүхэн үйл ажиллагааны тайлантай танилцана уу.

Сангийн гүйцэтгэл

Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС ХХК /цаашид “Сан” гэх/-ийн нийт хөрөнгө 2023 оны 01-р сарын 30-ны байдлаар 6.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 56.3 тэрбум төгрөгт хүрсэн байна. Энэ нь анхны үнэлгээнээс 12.7 хувиар өсжээ.

Цэвэр хөрөнгийн үнэ цэн нь хөрөнгө оруулалтын сангийн хувьд нэгж эрхийн үнийг тодорхойлогч гол хүчин зүйл байдаг. Сангийн хувьд тус үзүүлэлт өссөөр байгаа бөгөөд сарын эцэст 1,126.8 төгрөг байна. Сангийн нэгж эрх мөн оны 01-р сарын 02-ны өдөр 871.6 төгрөгөөр арилжаалагдаж эхэлсэн бол сарын эцэст 868.28 төгрөгөөр арилжаалагсан нь 0.4 хувийн бууралттай дүн юм.

Сангийн хөрөнгийн бүтэц

2023 оны 01-р сарын байдлаар хөрөнгө оруулалтын багцын 22 хувийг хувьцаа, 39 хувийг эрсдэл бага, тогтмол өгөөж бүхий бондод байршуулсан бол үлдсэн 39 хувийг мөнгөний захын хэрэгсэлд байршуулсан. Сангийн хөрөнгө оруулалтын багцыг салбараар харвал санхүүгийн салбар 87.6 хувь, үйлдвэрлэлийн салбар 12.1 хувь мөн уул уурхайн салбар 0.3 хувийг тус тус эзэлж байна.

Монгол улсын эдийн засгийн төлөв байдал

Төсвийн Сектор

2022 оны эхний 10 сарын байдлаар Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1.0 их наяд төгрөгийн алдагдалтай гарсан. Нэгдсэн төсвийн орлого 2021 оны 10-р сард 2020 оны үеэс 44.1 хувиар өсөж, 11.9 их наяд төгрөгт хүрээд байсан бол 2022 онд энэ үр дүн 8.6 хувиар өсөж, 13.0 их наяд төгрөгт хүрээд байна. Татварын орлогын өсөлтөд ААНОАТ 15.0 хувиар буурсан нь сөрөг нөлөө үзүүлж буй. ААНОАТ-ын орлого буурсан бол ХХОАТ 19.9 хувиар, нийгмийн даатгалын орлого 36.7 хувиар, НӨАТ-ын орлого 37.3, гадаад үйл ажиллагааны орлого буюу гаалийн тариф 36.9 хувиар өссөн байна. Өөрөөр хэлбэл, Засгийн газар 2022 онд төсвийн орлогыг бизнесийн орлогоос бус иргэдийн орлогоос бүрдүүлэх болжээ. Хэдийгээр дотоодод цар тахлын хөл хориог сулруулсан ч олон улсын эдийн засгийн орчин тааламжгүй байгаагаас бизнесүүд орлогоо алдаж байгаа тул төсвийн орлогоо хангалттай бүрдүүлж чадахгүй байна.

Засгийн газраас татвар, нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, урсгал шилжүүлэг, цалин хөлсний зардлыг нэмэгдүүлэх замаар дотоод эдийн засаг дахь эрэлтийг дэмжих зорилгоор мөчлөг сөрсөн төсвийн бодлогыг 2020 оноос эхлэн хэрэгжүүлж эхэлсэн. Цар тахлын нөлөөгөөр 2020 онд Монгол Улсын нийт төсвийн алдагдал ДНБ-ний 9.6 хувьтай тэнцэж байсан бол 2021 онд 3.4 хувьтай тэнцэж байв.

2022 оны 6 дугаар сарын нэгнээс өрхүүдийн цахилгаан, усны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээ зогсоосноор урсгал шилжүүлгийн зардал буурах боломжтой. Түүнчлэн танах боломжтой хөрөнгө оруулалтын болон урсгал зардлуудыг бууруулснаар 2022 онд төсвийн зардал буурах боломжтой хэдий ч их хэмжээгээр буурах хүлээлтгүй байгаа юм. 2023 онд Засгийн газрын гадаад өр төлөгдөж эхэлснээр төсвийн зардал үлэмж хэмжээгээр нэмэгдэхээр хүлээлт үүснэ. Ковид-19 цар тахлын эдийн засагт үзүүлэх нөлөөллийг багасгах, хүн амын эрүүл мэндийг хамгаалахын тулд Засгийн газраас авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээнүүд цаашид ч үргэлжлэх төлөвтэй байна. Цаашид хил гаалийн хязгаарлалт, олон улсын геополитикийг тойрсон тодорхойгүй байдал буурахгүй төсвийн тэнцлийн алдагдал 2022 онд ДНБ-ий 5.0, 2023 онд 2.8, 2024 онд 2.8 орчим хувьтай тэнцүү байхаар хүлээгдэж байна.

Инфляц

2021 оны эхний 3 сард цар тахлын өвчлөлийн тохиолдол нэмэгдсэн нь улс орнуудад дотооддоо хөл хорио тогтоохоос өөр аргагүй байдалд хүргэснээр хилийн хязгаарлалт тогтоож, үйлдвэрлэлийн гарц огцом буурсан. Энэ нь улс орнуудад 2-3 сарын хоцрогдолтойгоор нийлүүлэлтийн гаралтайгаар нөлөөлсөн бөгөөд Монгол Улсад 2021 оны 6-р сараас эхлэн инфляцын түвшин огцом нэмэгдсэн.

Улмаар 2022 оны 10-р сард хэрэглээний үнийн өсөлт 14.5 хувьд хүрлээ. Тус өсөлтөд хүнсний зардал 16.4 хувиар өссөн нь голлох нөлөө үзүүлсэн ба эм тариа, эмнэлгийн үйлчилгээ 20.6 хувиар, зочид буудал, нийтийн хоолны үйлчилгээ 18.6 хувиар, гэр ахуйн бараа 15.8 хувиар тус тус өссөн нь мэдэгдэхүйц нөлөө үзүүлжээ. Дэлхий дахинаа цар тахлын хөл хорионоос шалтгаалан үүсээд байсан

нийлүүлэлтийн гацаа бага багаар арилж байгаа нь тээврийн инфляцд үүсэх дарамтыг сүүлийн 4 улирлын турш дарааллан бууруулжээ.

Монгол Улсын хэрэглээний сагсны 40 орчим хувийг импортын бараа бүтээгдэхүүн эзэлдэг. Импортын барааны үнийн өсөлт нэмэгдэхэд шатахууны үнийн өсөлт голлон нөлөөлдөг. Өөрөөр хэлбэл, газрын тосны дэлхийн зах зээл дээрх үнийн өсөлт, бараа бүтээгдэхүүний тээвэрлэлтийн хүндрэл, хил гаалийн нөхцөл байдлаас шалтгаалан Монгол Улсын хэрэглээний үнэ нийлүүлэлтийн гаралтай өссөн.

Сангийн 2022 оны Санхүүгийн тайлан, Ногдол ашиг хувиарлах эсэх

Сангийн ТУЗ-н зүгээс 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг үндэслэн 2022 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах эсэх асуудлаар танилцуулж санал хураалаа. Хуралд оролцсон ТУЗ-н гишүүдийн 100% саналаар ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэв.

МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ <small>ХАМТЫН ХОС ХХК</small>			САНХҮҮГИЙН ТАЙЛАН <i>(Мянган төгрөгөөр)</i>		
<i>Хүснэгт 3. Санхүүгийн тайлан</i>			<i>Хүснэгт 4. Орлогын тайлан</i>		
Үзүүлэлт	2021 он	2022 он	Үзүүлэлт	2021 он	2022 он
Монго, түүнтэй адилтгах хөрөнгө	4,027.62	1,817,899.68	Борлуулалтын орлого (цэвэр)	1,486,013.14	4,452,607.68
Авлага	427,008.11	11,411,911.76	Хүүний орлого	1,081,229.18	4,111,689.03
Урьдчилж төлсөн зардал/гооцоо	985,305.53	64,216.29	Ногдол ашгийн орлого	-	37,579.33
Бусад санхүүгийн хөрөнгө	49,711,956.02	42,635,588.97	Бусад орлого	404,783.96	303,339.32
Хойшлогдсон татварын хөрөнгө	45,456.63	45,456.63	Нийт зардал	418,248.99	2,333,260.35
Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
Нийт хөрөнгийн дүн	51,173,753.91	55,975,073.34	Ерөнхий ба удирдлагын зардал	418,248.99	2,256,861.76
Богино хугацаат ор төлбөр	-	552,466.02	Бусад зардал	-	76,398.59
Урт хугацаат ор төлбөрийн дүн	172,269.70	213,238.26	Гадаад валютын ханшийн зөрүүний өлз (гарз)	-	1,314,470.20
Өмч	51,001,484.21	55,209,369.05	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	1,067,764.15	3,433,817.54
Хувийн	50,000,000.00	50,000,000.00	Орлогын татварын зардал	66,279.94	546,839.85
Хувьцаат	-	-	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1,001,484.21	2,886,977.69
Хуримтлагдсан ашиг	1,001,484.21	3,888,461.90	Бусад дэлгэрэнгүй орлого	-	1,320,907.15
Эздийн өмчийн бусад хэсэг	-	1,320,907.15	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	1,320,907.15
Нийт ор төлбөр эздийн өмчийн дүн	51,173,753.91	55,975,073.34	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	1,001,484.21	4,207,884.84

Тайлант жилийн гүйцэтгэл 9.38%

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б.ЭНХТҮВШИН

Хурлын тэмдэглэлтэй танилцаж зөвшөөрсөн:

ДАРГА

ГИШҮҮД



Ө.ГАНЗОРИГ

Н.МОНСОР

Ч.АНХБАЯР

Ц.БАТСҮХ

МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

2023 оны 02 сарын 16 өдөр

№ 01

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

“Ногдол ашиг хуваарилах эсэх тухай”

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, “Мандал Ирээдүйн өсөлт” хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сан (“ХОС” гэх)-ийн дүрмийн 10 дугаар зүйл 10.4.7 хэсгийг тус тус удирдлага болгон ХОС-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. Мандал Ирээдүй Өсөлт” хөрөнгө оруулалтын сан нь хөрөнгө оруулалтын бодлогод заасны дагуу эдийн засгийн өсөлтийг хангах зорилгоор 2022 оны цэвэр ашгаас ХОС-ийн нэгж эрх эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.
2. Ногдол ашиг хуваарилахгүй тухай тогтоол мэдэгдлийг ХОС-ийн нэгж эрх эзэмшигчид, олон нийт, эрх бүхий байгууллагад мэдэгдэх ажлыг зохион байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад үүрэг болгосугай.

ДАРГА



Ө:ГАНЗОРИГ